

Төлөвлөгөөт хяналт шалгалт
хийсэн тухай

Хяналт шалгалтын зорилго

Санхүүгийн хяналт аудитын албаны 2017 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө, Санхүүгийн хяналт аудитын албаны даргын баталсан 2017 оны 04 сарын 10-ны 1/07 дугаар удирдамжийн дагуу санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох дүрэм, журам, тушаалуудын хэрэгжилтийг хангуулах, үндсэн үйл ажиллагааны байдал, зохион байгуулалт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагааны байдлыг шалгаж, үнэлэлт дүгнэлт өгөх, ололт амжилтыг бататгаж, зөрчил дутагдлыг арилгахад оршино.

Хяналт шалгалтын бүрэлдэхүүн, албан тушаал, хугацаа

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч О.Гантуяа
2017 оны 04 дугаар сарын 23-аас ажлын 6 хоног

Шалгалтанд хамрагдсан байгууллага, объектын нэр

Бүрэгхангай сумын Эрүүл мэндийн төвийн 2016 онуудын санхүү, аж ахуйн үйл ажиллагаа хамрагдав.

Шалгалтанд хамрагдсан асуудал

Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн гаргасан заавар, журам, дүрмийн хэрэгжилтийн байдал

Үйл ажиллагааны орлого, зарлагын төлөвлөлт, түүний гүйцэтгэлийн байдал
Харилцах дансны болон кассын орлого, зарлагын гүйлгээг үндсэн баримтууд, бараа материалын тайлан, хөрөнгийн бүртгэл, нягтлан бодох бүртгэлийн журналууд, дансны бичилтүүдтэй тулган шалгах

Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, тайлан тэнцэл гаргалт, хөрөнгийн тооллого, тооцоо бодолтын байдал

Байгууллага хоорондын тооцоо өглөг авлага, түүний баталгаажуулалт, бүртгэл тайланд тусгасан байдал

Ажиллагсдын цалин хөлс, шагнал урамшууллыгхууль тогтоомжийн дагуу тогтоож, бодож олгосон байдал

Гадаад, дотоод албан томилолтын зардлын тооцоо төлсөн байдал
Автомашин ашиглалт, шатахуун, сэлбэгийн тооцоо бодолтын байдал
Зээл тусламж, эргэж төлөгдөх нөхцлөөр ашиглуулж байгаа төсвийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалт үр дүн

Тэмдэглэлт өдөр, ой, баяр наадамд зарцуулсан хөрөнгийн байдал
Нягтлан бодогчийн хууль тогтоомжинд заасан үүргийн биелэлт
Өмнөх шалгалтаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, актын барагдуулалт

Дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байдал

Шалгалтанд хамрагдсан объектын талаарх

товч мэдээлэл

Бүрэгхангай сумын Эрүүл мэндийн төв нь их эмч 3, статистикч бага эмч 1, эх баригч бага эмч 1, Багийн бага эмч 3, сургалтын арга зүйч 1, лаборант 1, нярав бичиг хэрэг 1, ээлжийн сувилагч 4, үйлчлэгч 2, тогооч, жолооч, сантехникч тус бүр 1 нийт 20 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна.

2016 оны 01 сарын 01-нээс 2016 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэл 1-р гарын үсгийг дарга Ж.Отгонтуяа, 2-р гарын үсгийг нягтлан бодогч Б.Энхцэцэг нар тус тус зурсан ба төрийн санд бүртгэлийн 040320001 тоот данс, нэмэлт санхүүжилтийн 040320401 тоот данстайгаар орлого, зарлагын гүйлгээг хийж, хөрөнгө мөнгийг захиран зарцуулж иржээ.

Нягтлан бодох бүртгэлийг санхүүгийн тооцоолох “CTS” программаар бүртгэж хөтөлсөн байна.

Өмнөх шалгалтын талаар

Эрүүл мэндийн төвийн 2016 оны санхүүгийн тайлан түүвэрт хамрагдсан, эрүүл мэндийн төвийн 2016 оны санхүү аж ахуйн үйл ажиллагаанд бусад байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Шалгалтын явцад хийгдсэн ажил, шийдвэрлэсэн асуудал

Тус Эрүүл мэндийн төвийн 2016 оны касс, харилцахын баримт, няравын материалын тайлан, нягтлан бодох бүртгэлийн журнал, эрхлэгчийн тушаал, цалингийн карт, цалин олгох хүснэгт, нийгмийн даатгалын болон татварын, санхүүгийн тайлан зэрэг баримт материалуудад тулгуурлан эрхлэгч эмч Ж.Отгонтуяа, нягтлан бодогч Б.Энхцэцэг, нярав М.Сарантуяа нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийлээ.

Санхүүжилт, орлогын талаар: /мянган төгрөг/

2016 оны төсвийг анх 301955.4 мянган төгрөгөөр төлөвлөсөн ч хасах тодотгол хийж 671.3 мянган төгрөг хасагдаж, 301284.1 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 301284.1 мянган төгрөгийг авч, урьд оны хувь хүмүүсээс авах авлага 1113.1 мянган төгрөгийг барагдуулж, туслах үйл ажиллагааны орлогоор түрээсийн орлого 742.5 мянган төгрөг орж, нийгмийн даатгалын сангаас ХЧТА-ны тэтгэмж 5 хүн нийт 1996.8 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтаар 4884.0 мянган төгрөг нийт 310020.5 мянган төгрөгийн эх үүсвэртэй ажилласан байна.

Төсөвт зардлын талаар /мян.төг/

2016 онд төсөвт зардлыг 301284.1 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 305136.6 мянган төгрөгийг зарцуулсан байна. Ажилчдын цалинд 153186.8 мянган төгрөг, нэмэгдэл цалинд 12559.5 мянган төгрөг, ндш-д 18214.6 мянган төгрөг, тогтмол зардалд 61261.5 мянган төгрөг, хангамжийн бараа материалд 14936.5 мянган төгрөг, нормативт зардал буюу эм 16547.2 мянган төгрөг, хоол хүнс 5999.9 мянган төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэл 2000.0 мянган төгрөг, эд хогшил болон урсгал зардалд 2504.4 мянган төгрөг, томилолт 1301.8 мянган төгрөг, төлбөр хураамж бусад татварууд 233.5 мянган төгрөг, хөтөлбөр төсөл 9072.9 мянган төгрөгийг тус тус зарцуулж, үлдэгдэл 5320.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Эрүүл мэндийн төвийн даргын 2016 оны 03 сарын 22-ны өдрийн А/05 дугаартай тушаалаар 1 улиралд 8 ажилтанд 30-45%-иар 1644.7 мянган төгрөгийн, 2016 оны 07 сарын 19-ний өдрийн А/12 дугаартай тушаалаар 2 улиралд 16 ажилтанд 30-45%-иар 3080.8 мянган төгрөгийн, 2016 оны 11 сарын 14-ний өдрийн А/08 дугаартай тушаалаар 3 улиралд 16 ажилтанд 30-45%-иар 2896.5 мянган төгрөгийн, 4 улиралд тушаал шийдвэргүйгээр 18 ажилтанд 45-65%-иар 4196.9 мянган төгрөгийн нийт 11818.9 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулалт цалин олгосон байна.

Эрүүл мэндийн төвийн эрхлэгч эмч Ж.Отгонтуяа нь 2016 оны 2 улиралд үндсэн цалингийн 30%-иар 200.6 мянган төгрөг, 3 улиралд үндсэн цалингийн 45%-иар 301.0 мянган төгрөг нийт 501.6 мянган төгрөгийн урамшуулалт цалинг ажлын шалгуур үзүүлэлтийг дүгнэсэн баримт болон эрх захирагчийн шийдвэргүйгээр авсан байна. Жилийн эцэст Бүрэгхангай сумын Засаг даргын 2016 оны 12 сарын 14-ний өдрийн Б/19 дүгээр захирамжаар үр дүнгийн гэрээгээ В үнэлгээгээр үнэлүүлж үндсэн цалингийн 80%-иар 535.1 мянган төгрөгийн урамшуулалт цалин авсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын тайлангаар:

2016 оны үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 348632.3 мянган төгрөг дээр ЭМГ-аас зүрхний цахилгаан бичлэгийн аппарат 1800.0 мянган төгрөг, Dell компьютер 2136.8 мянган төгрөг нийт 3936.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгөнд орлогодож 352569.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна.

Бараа материалын 2016 оны эхний үлдэгдэл 28365.0 мянган төгрөг дээр эм боох материал 16236.4 мянган төгрөг, бичиг хэрэг 612.5 мянган төгрөг, аж ахуйн материал 5860.0 мянган төгрөг, түлш, шатах тослох материал 10161.5 мянган төгрөг, засварын материал 1013.4 мянган төгрөг, хүнсний материал 5999.9 мянган төгрөг, бусад хангамжийн материал 2440.3 мянган төгрөг нийт 42324.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 166.0 мянган төгрөгийн хүнсний материал, 345.0 мянган төгрөгийн аж ахуйн материал хандиваар авч, 35000.9 мянган төгрөгийн материалыг үйл ажиллагаандаа зарцуулж, 5485.6 мянган төгрөгийн аж ахуйн материал акталж оны эцэст 30713.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна

Өглөг, авлагын талаар: Эрүүл мэндийн төв нь 2016 онд өглөг, авлагагүй тайлан гарсан байна.

Нэмэлт санхүүжилт: Нэмэлт санхүүжилтийн дансанд 2015 оны татан төвлөрүүлсэн үлдэгдэл 1000.0 мянган төгрөг, Эрүүл мэндийн газраас шатахууны зардалд 216.5 мянган төгрөг, Бодь бүрэг ХХК-аас түрээсийн орлого 247.5 мянган төгрөг, иргэдээс 3220.0 мянган төгрөг, Айрхан бүрэг баяр ХХК-аас 200.0 мянган төгрөг, хувь хүнээс суутгасан хүн амын орлогын албан татвар 53.6 мянган төгрөг нийт 4937.6 мянган төгрөг орж ирсэнийг дараах зардлуудад зарцуулсан байна. 2000.0 мянган төгрөгийг урлагийн арга хэмжээнд, 1788.0 мянган төгрөгийг барилгын засварт, Эмоци энтертайнментийн хоолны зардалд 600.0 мянган төгрөг, шатахууны зардалд 216.5 мянган төгрөг, материалын зардалд 185.0 мянган төгрөг, хүн амын орлогын албан татварт 65.6 мянган төгрөгийг зарцуулсан ч зарцуулалтын тайлан байхгүй, 82.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Шилэн дансны талаар: Эрүүл мэндийн төв нь шилэн дансны хуулийн дагуу 2016 онд мэдээллийг тавьсан ч батлагдсан төсөв гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгааны, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, концессын зүйлийн жагсаалтын, байгууллагын орон тоонд орсон өөрчлөлтийн, аудитын тайлан, худалдан авах ажиллагаанд хийсэн тайлан зэрэг нийт 72 мэдээлэлийг хоцроож байршуулсан.

Бүрэгхангай сумын ЭМТ-ийн 90 жилийн ойн арга хэмжээний хандивын орлого болон зарцуулалтын талаар:

Бүрэгхангай сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2016 оны 03 сарын 23-ны 16 тоот тогтоолоор Эрүүл мэндийн төвийн түүхт 90 жилийн ойн арга хэмжээг 2016 оны 07 сарын 29-30-ны хооронд зохион байгуулах, ажлын төлөвлөгөө, ажлын хэсэг зохион байгуулах комиссыг баталж, тэмдэглэн өнгөрүүлсэн байна.

Ойн хүрээнд Баян тосон буудай ХХК-аас 1500.0 мянган төгрөг, Өрмөн уул ХХК-аас 3000.0 мянган төгрөг, Эвсэг сайхан ХХК-аас 2000.0 мянган төгрөг, Төсөлч ХХК-аас 2000.0 мянган төгрөг, иргэн Баатарчулуунаас 1000.0 мянган төгрөг, Мөнхболдоос 1000.0 мянган төгрөг, Бүрэнтогтохоос 1000.0 мянган төгрөг болон нэр бүхий 38 иргэнээс 3835.0 мянган төгрөг нийт 15335.0 мянган төгрөгийг бэлнээр 1,2,3 дугаар багийн 134 малчдаас адуу-5, үхэр-5, хонь-119, ямаа-88 нийт 217 толгой

малыг 13670.0 мянган төгрөгөөр үнэлсэн, ЭМТ-ийн нэмэлт санхүүжилтийн дансаар 3420.0 мянган төгрөг, ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн данснаас 8000.0 мянган төгрөг нийт 40425.0 мянган төгрөгийн хандивын орлогыг бүрдүүлжээ.

Эрүүл мэндийн төвийн ойн арга хэмжээний хүрээнд ЭМТ-ийн түүхэн ном хэвлүүлэх, хуучин эмнэлгийн байрны гадна засвар, эмнэлгийн гадна хашааг шинэчлэх, урд эмнэлгийн дотор засвар зэрэг бүтээн байгуулалтын ажил хийх, баяр наадам, хүлээн авалт, зочид төлөөлөгчдөд бэлэг дурсгалын зүйл олгох зэрэг зардлуудыг төлөвлөж нийт 40425.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Зарцуулалтын талаар:

- ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн даснаас 8000.0 мянган төгрөгөөр 500 ш ном, 250ш урилга, 250ш тор зэргийг хэвлүүлсэн.
- Хуучин эмнэлгийн барилгын гадна засварын ажлыг иргэн Лхагвасүрэнтэй гэрээ байгуулж 2016 оны 07 сарын 10-30-ны хооронд 6000.0 мянган төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулж, нэмэлт санхүүжилтийн данснаас 1800.0 мянган төгрөгийг өгч үлдэгдэл 4200.0 мянган төгрөгийг бэлнээр өгсөн.
- Зочид төлөөлөгчдөд ширээний цаг, тэмдэглэлийн дэвтэр түүхэн замналын ном зэргийг хандивлагч иргэдэд өгсөн.
- Ойн арга хэмжээнд Эмоци интертайментийнхэн баярын концерт, үдшийн цэнгүүнийг зохион байгуулж ажлын хөлс, хоолны зардалд 2600.0 мянган төгрөгийг зарцуулсан.
- Ойн баярын арга хэмжээний баярын хурлын үеэр иргэд, нутгийн зөвлөлөөс хөргөгч, хөлдөөгч, зурагт, принтер зэрэг биет хөрөнгө хандивласныг үнэ тогтоож үндсэн хөрөнгөнд орлогодоогүй
- Мөн хандивын орлогоор авсан 5254.0 мянган төгрөгийн аж ахуйн материал, 4083.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг 2017 оны 01 сард орлогодсон байна.
- ЭМТ-ийн түүхт 90 жилийн ойн арга хэмжээний үеэр зохион байгуулагдсан ажлын тайлан, санхүүгийн эх үүсвэр, хандив тусламж, хөрөнгө мөнгөний зарцуулалтын тайлан хангалтгүй байна.

Баяр наадмын үйл ажиллагааны зардалд

№	Ойн арга хэмжээний шагнал	Шагналын хэмжээ
1	Бөхийн бай шагнал	990.0
2	Соёолон морины шагнал	1350.0
3	Дааганы бай шагнал	1050.0
4	Сур харвааны шагнал	860.0
5	Айраг	375.0
	Дүн	4625.0

Шалгуулагчийн ололттой болон дэвшилттэй тал

1. Санхүүгийн тайлан балансыг цаг хугацаанд гаргаж тушаасан

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал

1. Хүнс болон бараа материалд агуулахын бүртгэл хөтөлдөггүй, шатахууныг авсан хэмжээгээр зардалд тусгадаг, жолоочтой шатахууны хэтрэлт, хэмнэлтийг тооцоог бодож акт үйлддэггүй.
2. ЭМТ-ийн даргын 2016 оны А болон Б тушаалуудыг үдэж архивлаагүй, Ажилд томилох тухай 2016 оны 05 сарын 23-ны Б/13 тоот тушаалын дугаар нь 07 сарын 07-ны Ажлаас чөлөөлөх тушаалын дугаартай, Ажил хавсран гүйцэтгүүлэх 2016 оны 11 сарын 01-ны А/10 тоот тушаалын дугаар нь 12 сарын 19-ны Хөрөнгө гаргах тухай тушаалуудын дугаар тус тус давхардсан байна.
3. Цалин олгох болон цалингийн тооцооны хүснэгт, цалингийн картанд ажиллагсдаар гарын үсэг зуруулаагүй байна.
4. Багийн бага эмч Д.Наранбаатар, сувилагч Б.Баярцэцэг, Э.Нэргүй, Б.Халиунаа нарт сахилгын хариуцлага тооцож нэг сарын үндсэн цалинг 20%-иар бууруулахаар байгууллагын даргын тушаал гарсан ч цалинг бодохдоо үндсэн цалингаас бууруулаагүй тухайн сарын орон нутгийн нэмэгдлийг хасаж тооцон олгосон.
5. Сувилагч Э.Нэргүйд вакцинаторыг хавсруулж 20%-иар 794.1 мянган төгрөг, сургалтын арга зүйч Д.Алтанцэцэгт эмийн няравын ажлыг хавсруулж 10%-иар 783.0 мянган төгрөг, нярав М.Сарантуяад бичиг хэргийн ажлыг хавсруулж 30%-иар 1114.8 мянган төгрөг, Б.Халиунаа ээлжийн сувилагчийг хавсруулж 40%-иар 373.0 мянган төгрөг, Д.Наранбаатар 207.4 мянган төгрөг, Т.Баян-өлзий 223.4 мянган төгрөгийг тус тус өгч батлагдаагүй орон тооны ажлыг хавсруулан нийт 3495.7 мянган төгрөгийн цалинг илүү тооцож олгосон.
6. Төсөл хөтөлбөрийн зардлаас 2341.0 мянган төгрөг, бичиг хэргийн зардлаас 90.0 мянган төгрөг, хоолны зардлаас 164.5 мянган төгрөг, нийт 2595.5 мянган төгрөгийг нярав М.Сарантуяагийн ХААН банкин дахь 5274085168 тоот харилцах дансаар дамжуулан гаргасан ч бэлэн мөнгөний тайлан гаргаагүй, 2000.0 мянган төгрөгнөөс хувь хүний орлогын албан татвар тооцоогүй байна.
7. ЭМТ-ийн дарга Ж.Оюунтуяаг их эмчийн цалингаар цалинжуулж, даргыг хавсран ажилласны 40%-ийг олгох байтал даргын цалингаар цалинжуулж их эмчийн 40%-иар хавсруулан 4 дүгээр сарын цалинд 530.1 мянган төгрөгийг олгосон байна.
8. Эрүүл мэндийн төвийн эрхлэгч эмч Ж.Отгонтуяад 2016 оны 2 улиралд үндсэн цалингийн 30%-иар 200.6 мянган төгрөг, 3 улиралд үндсэн цалингийн 45%-иар 301.0 мянган төгрөгийг ажлын шалгуур үзүүлэлтийг дүгнэсэн баримт болон эрх захирагчийн шийдвэргүйгээр 501.6 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулалт цалин олгосон нь Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно./ 13.7-д /Анхан

шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгахыг хориглоно./ заасан заалтуудыг зөрчсөн зөрчил илэрлээ.

9. Эрхлэгч эмч Ж.Отгонтуяагийн 2, 3 улирлын үр дүнгийн урамшууллын захирамжийг нөхөж гаргахдаа хагас бүтэн жилийн ажлыг дүгнэж олгодог 2012 оны 134 дүгээр тогтоолыг үндэслэн захирамж гаргасан нь үндэслэл буруу захирамж гаргасан байв.
10. Эмийн тайлангийн эхний үлдэгдэл 4121.2 мянган төгрөг байхад, санхүүгийн тайлангийн үлдэгдэл 4116.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэйгээр тайлагнаж 5.0 мянган төгрөгийн зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16.5.7 дахь заалтыг зөрчин санхүүгийн тайланг буруу тайлагнасан байна.
11. ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн данснаас 31000.0 мянган төгрөг, ОНХСангаас 9000.0 мянган төгрөг, ЭМТ-ийн түлш халаалтын зардлаас 8000.0 мянган төгрөг нийт 48000.0 мянган төгрөгийг гаргаж Эрүүл мэндийн төвийн барилгын засварыг “Содон чимээ” ХХК-иар хийлгэж хүлээн авсан боловч үндсэн хөрөнгөнд капиталжуулж орлогодоогүй. ЭМТ-ийн түлш халаалтын зардлаас гаргасан 8000.0 мянган төгрөгийг урсгал засварын зардалд шилжүүлэн зарцуулах эрх захирагчийн шийдвэргүй, үндсэн баримтгүйгээр гүйлгээ хийгдсэн байна.
12. Бүрэгхангай сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн данснаас 8150.0 мянган төгрөг, ОНХСангаас 8000.0 мянган төгрөг нийт 16150.0 мянган төгрөгөөр Дүүрэн ирээдүй ХХК-иар бариулсан хашаа, хандивын орлогоор авсан 5254.0 мянган төгрөгийн аж ахуйн материал, 4083.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг 2016 онд орлогодоогүй, 2017 оны 01 сарын 01-нд орлогодсон байна.
13. Улаанбаатар хотын Сэлэнгэ пресс ХХК-ний 5000234818 тоот дансанд 8000.0 мянган төгрөгийг шилжүүлж ном хэвлүүлсэн ч тайлан балансад тусгаагүй.
14. Эрүүл мэндийн төв нь ЗДТГ-т хандиваар ирсэн 30 тн цементээс 351 шуудай буюу 17.5 тн цементийг авч хашаа болон барилгын засварт үлдэгдэлгүйгээр хэрэглэсэн ч, үнэлж данс бүртгэлд тусгаагүй, мөн нэмэлт санхүүжилтийн дансанд орсон 4884.0 мянган төгрөгийн хандив болон дээд шатны байгууллагын санхүүжилтийн зарцуулалтын тайлан байхгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.3.4-д /төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх/ гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Авсан арга хэмжээ, мэргэжлийн туслалцаа,
зөвлөгөө өгсөн байдал**

Санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж таслан зогсоох зорилгоор 4 заалттай 1 албан шаардлага, 2 заалттай 1206.2 мянган төгрөгийн төлбөрийг аймгийн төсөвт төвлөрүүлэхээр 2 акт

тогтоолоо. Шалгалтын хугацаанд 4 албан тушаалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

Дүгнэлт

Тус ЭМТ-д Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.7 дахь заалтууд, агуулахын бүртгэлийн дэвтэр хөтлөөгүй, шатахууныг хэтрэлт, хэмнэлтээр тооцож акт үйлдээгүй, төсвийн тухай хуулийн 6.3.4, 16.5.7 дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй, эмийн тайлан, жилийн эцсийн санхүүгийн тайлан зөрүүтэй байгаа зэрэг нь байгууллага дотооддоо бүртгэлээр тавих дотоодын хяналт хийгдээгүй гэж дүгнэлээ.

Цаашид анхаарах асуудал

Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, төсвийн тухай хуулийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах

Санхүүгийн үйл ажиллагаандаа дотоодын хяналт шалгалтыг тогтмол хийж санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх

Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу албан ёсны баримтыг үндэслэн зарцуулж байх

Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоож, давтан гаргахгүй байх талаар анхааран тодорхой ажил зохион байгуулж, акт, албан шаардлагын биелэлтийг албан тоотоор хүргүүлж ажиллах

БИЧСЭН: САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН
БАЙЦААГЧ О.ГАНТУЯА

